



**ОРХОН АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 1/42

Баян-Өндөр сум

Байгууллагын ёс зүйн дэд
хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 13 дугаар зүйлийн 13.2, 13.3 дахь хэсэг, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны "Журам батлах тухай" 05 дугаар тогтоол, Байгууллагын албан хаагчдын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хурлын шийдвэр, уг хурлаар Ёс зүйн дэд хорооны гишүүдээр сонгогдсон албан хаагчдын мөн өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын "Ёс зүйн дэд хороо"-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга Б.Төгөлдөржаргал-Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн

Гишүүн Г.Бямбацогт-Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга А.Сарангэрэл-Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн

2. Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хянан шалгаж, дүгнэлтийг танилцуулах, холбогдох журмын дагуу мэдээ тайланг хагас бүтэн жилээр гаргаж, холбогдох газруудад хүргүүлж ажиллахыг Ёс зүйн дэд хороо /Б.Төгөлдөржаргал/-д үүрэг болгосугай.

3. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг зохих журмын дагуу улирал тутамд олгохыг ерөнхий нягтлан бодогч /Б.Батсайхан/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/30 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.ЭРДЭНЭЧИМЭГ

D:/ Tushaal/A-4.doc

612501032

**Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын Ёс зүйн дэд хорооны
2025 оны үйл ажиллагааны тайлан**

2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

Баян-Өндөр сум

Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр боловсруулж, газрын даргаар батлуулсан.

Уг төлөвлөгөөнд байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилго бүхий нийт 8 арга хэмжээ тусгагдсан.

2025 оны 4 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны Орхон аймаг дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүнг хэлэлцэх, төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн **“Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал”** сэдэвт хойд бүсийн зөвлөгөөнд нийт албан хаагчдыг хамруулж, оролцоог хангансан.

Мөн аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын сэтгэлзүйч нартай хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр бүх албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан ба 2025 оны 06 дугаар сарын 04-нөөс 06-ны өдрүүдэд тус газрын сэтгэлзүйч Б.Болдсайхан, О.Өнөржаргал, Э.Соёл-Эрдэнэ нар дээр байгууллагын 12 албан хаагчийг өөрсдийнх нь саналыг үндэслэн хувиарлаж ганцаарчилсан зөвлөгөөнд хамруулсан.

Ганцаарчилсан зөвлөгөөний үеэр албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, стрессийн шалтгаан, нөлөөлөл, түүнийг даван туулах арга замын талаар онол, практик хосолсон хэлбэрээр мэдлэг олгож, хувь хүний сэтгэлзүйн хэрэгцээ, тулгамдсан асуудлыг сонсох, дэмжих, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд илүү анхаарсан бөгөөд тус үйл ажиллагаа нь албан хаагчдын сэтгэлзүйн эрүүл мэндийг дэмжих, ёс зүйн хариуцлагыг төлөвшүүлэх, ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үр дүнтэй арга хэмжээ болсон.

Тайлант хугацаанд Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 105 тоот албан бичгээр ирүүлсэн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Баттөр нь “манай байгууллагын 2025 оны бизнес төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлаагүй байхад ажил албан тушаалаа урвуулан ашиглаж би танай байгууллагын ТУЗ-ын тэргүүлэгч болж магадгүй гэж байгууллагын ажилтан албан хаагчдыг өрөөндөө дуудаж дарамтлан дээрх баримт бичгийг авсан” гэх гомдлыг 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авч 5 иргэнээс тайлбар авч, холбогдох бусад шалгалтын ажиллагааг явуулж Ёс зүйн дэд хорооны 2025 оны 02

дугаар сарын 24-ний өдрийн 01 дугаартай дүгнэлтээр Б.Баттөрийг ёс зүйн зөрчил гаргаагүй гэж үзсэн бөгөөд уг дүгнэлтийг аймгийг Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлж ажилласан.

Байгууллагын албан хаагчийн ёс зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Ёс зүйн дэд хорооны гишүүн Г.Бямбацогт 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм"-ийн талаар, 2025 оны 10 дугаар сарын 07-ны Болор үйлсийн үндэс ТББ-ын Зүрх сэтгэлийн карьер сургалтын төвтэй хамтран "Төрийн албан хаагчдын ёс зүй, иргэдтэй харилцахад анхаарах асуудал, уур амьсгалын зэрэг болгох зам," "Хамт олны уур амьсгалыг зөөлрүүлэх нь" сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, албан хаагчдыг бүрэн хамруулсан.

Байгууллагын ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэх асуудлаар хамт олны хурлыг 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хийж ёс зүйн дэд хорооны даргаар Б.Төгөлдөржаргал, нарийн бичгийн даргаар А.Сарангэрэл, гишүүнээр Г.Бямбацогт нарыг сонгож "Байгууллагын ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах тухай" А/42 дугаар тушаалаар албажуулсан.

Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 06 дугаар тогтоолд заасан аргачлалын дагуу албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг 2025 оны 12 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд нийт албан хаагчдад хийлээ. Эрсдэлийн үнэлгээгээр нийт албан хаагчид "бага эрсдэлтэй" үнэлэгдэж байх тул "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 7.3 дахь хэсэгт зааснаар шууд арга хэмжээ авах шаардлагагүйгээр хяналтыг үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн ба цаашид ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтмол сургалт, зөвлөмжийг өгөхөөр төлөвлөн ажиллаж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10.2-т заасан шаардлагын дагуу Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшууллыг олгоогүй.

Тайлан гаргасан:


Ёс зүйн дэд хорооны гишүүн



/Г.Бямбацогт/

Тайланг хянасан:

Ёс зүйн дэд хорооны дарга



/Б.Төгөлдөржаргал